



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар A/192

Батширээт сум

Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/297 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 07 -ны өдрийн А/612 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоц халдварт хонины шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын сумын бүх үхрийг хамруулан 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд чанартай, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчилга өгч ажиллахыг "Баянбараат хайрхан" ХХК-ийн малын эмч Т.Бямбадорж, "Шүтээн дэнж" ХХК-ийн малын эмч Б.Мягмаржав, "Өглөгч сүрэг" ХХК-ийн малын эмч Ц.Ариунболд нарт үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулан, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд, малчдыг татан оролцуулж мэдээлэл хүргэн, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явцад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501379